

Аюурвед ба Монгол анагаах ухаанд мэс заслын өвчний ангиллын зарчмын харьцуулалт

Э.Даваадулам¹, Н.Батсайхан¹, Ч.Батнайрамдал²¹АШУУИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль²АШУУИС, Монгол анагаах ухааны төв эмнэлэг

Цахим шуудан: Btd24f053@gt.mn.ums.edu.mn, Утас: 95965333

Түлхүүр үг:

Сушрута Самхита,
Сэдэвчилсэн
кодчиллол
Данжуур
Агуулгын
шинжилгээ
Өвчний ангилал
зүй

Товч утга:

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухаан нь Энэтхэгийн Аюурвед, Төвөд болон Хятадын анагаах ухааны олон талт эх сурвалжийн уялдаа холбоонд тулгуурлан хөгжсөн өвөрмөц мэдлэгийн сан юм. Ялангуяа Аюурведийн суурь зохиол болох “Аштанга Хридая Самхита” нь Төвөд, Монголын анагаах ухааны идеологийн үндэс болсон Анагаах ухааны дөрвөн үндэс зохиогдоход гол нөлөө үзүүлсэн гэж судлаачид үздэг. Хэдийгээр МУАУ-ны түүхэн хөгжлийг Б.Жигмэд, Ш.Болд, Я.Ганбаяр нарын эрдэмтэд судалсан боловч Аюурведийн мэс заслын ойлголт Монгол ахуйд хэрхэн нутагшиж, анхны эх сурвалжаасаа хэрхэн хувьссаныг харуулсан текст хоорондын (intertextual) харьцуулсан судалгаа дутмаг байна. Иймд Сүмбэ хамба Ишбалжир, Миндол Номун Хаан Жамбалчойжиданзанпэрэнлэй зэрэг Монгол мэргэдийн бүтээлд туссан АВАУ-ны мэс заслын уламжлалыг илрүүлэн тогтоох нь МУАУ-ны түүхэн төлөвшилийг ойлгоход нэн чухал ач холбогдолтой юм. **Зорилго:** Монголын уламжлалт анагаах ухааны тодорхой эх сурвалжуудад Аюурведийн анагаах ухааны ойлголт, тэр дундаа өвчний ангилал зүй болон мэс заслын уламжлал хэрхэн туссаныг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан, Монгол эмч нарын эмнэлзүйн хэрэглээндээ хэрхэн уламжлан авч, баяжуулсан зүй тогтлыг гаргахад оршино. **Арга, аргачлал:** Судалгаанд Аюурведийн “Сушрута Самхита” (1907), “Аштанга Хридая Самхита” болон Монголын сурвалж бичгүүд болох Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан” (1994), Миндол Номун Хааны “Увдисын далай” (2014) зэрэг бүтээлүүдийг ашиглав. Судалгааг гүйцэтгэхдээ сэдэвчилсэн кодчиллол (Thematic analysis), агуулгын дүн шинжилгээ (Content analysis) болон эх сурвалж харьцуулан судлах аргуудыг ашигласан. Түүнчлэн сурвалж бичиг судлалд мэдээллийг цомхотгох зорилгоор кодлон ангилах (Coding) аргачлалыг хэрэглэв. **Үр дүн:** Сонгогдсон сурвалж бичгүүдэд агуулгын (Content analysis) болон сэдэвчилсэн кодчиллын (Thematic coding) шинжилгээ хийхэд Аюурведийн арга зүйд суурилсан, мэс ажилбар шаардах 28 төрлийн өвчний ангилал тодорхойлогдов. Үүнд гэмтэл согог, эрхтэн тогтолцооны эмгэгүүдээс гадна халдварт болон арьсны өвчнүүд багтаж байна. Сүмбэ хамба Ишбалжирын “Рашааны цагаан шүүхэр” бүтээлд эдгээр 28 өвчний 42.8%-ийг халдварт эмгэг, 23.8%-ийг бэртэл гэмтэл эзэлж байгаа бол “Увдисын Далай”-д халдварт өвчин 47.05%, бэртэл 24.0%-ийг тус тус эзэлж байна. Хоёр сурвалжид хоёуланд нь найман төрлийн кодоор шинжилгээ хийхэд “Эмчилгээ”-ний код хамгийн өндөр давтамжтай (n=22-25) илэрсэн нь Монгол мэргэд Аюурведийн практик заслын зааврыг түлхүү өвлөн авсныг харууллаа. **Дүгнэлт:** Аюурведийн мэс заслын болон өвчний ангиллын зарчим нь МУАУ-ны сурвалжуудад механикаар хуулбарлагдаагүй, харин Монгол орны цаг уур, ахуйн онцлогт тохирон системчлэгдсэн байна. Сүмбэ хамба Ишбалжир болон бусад Монгол эрдэмтэд Аюурведийн “Shalya Tantra” буюу мэс заслын ухааныг халдварт өвчин болон бэртэл гэмтлийг анагаах практик арга техникээр баяжуулан хөгжүүлсэн нь МУАУ-ны мэс заслын бие даасан хөгжлийг тодорхойлж байна.

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухаан (МУАУ) нь Төвөдийн анагаах ухааны онол-зүй, Энэтхэгийн Аюурвед болон Хятадын анагаахуйн зарим эмчилгээний арга, эм тан зэрэг олон эх сурвалжын уялдаа холбоонд тулгуурлан бүрэлдэн хөгжсөн өөрийн өвөрмөц соёлын цогц мэдлэгийн сан дээр бүрэлдэн тогтсон.² Эдгээрийн дундаас Аюурведын анагаах ухаан нь МУАУ-д нэлээд эртнээс нөлөөлж, эхэлсэн бөгөөд энэ нөлөө нь түүхэн эх сурвалж, орчуулгын уламжлал, эмчилгээний арга зүйн түвшинд тодорхой ул мөр үлдээсэн.

Аюурведын суурь зохиолуудын нэг болох “Аштанга Хридая Самхита” (*Aṣṭāṅga Hṛdaya Samhitā*) нь МЭ VIII зууны үеэс Төвдөд орчуулагдан түгсэн нь Төвөд анагаах ухааны тулгуур бүтээл болох “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” (АУДҮ) зохиогдох идеологийн үндэс, эмнэлзүйн зарчмуудын нэг эх суурийг бүрдүүлсэн гэж судлаачид үзсэн.^{2,1,10} Эрдэмтэн Б.Жигмэд (2009) Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээнд Монгол анагаах ухаан бол монгол соёлын системийн доторх чухал нэг хэсэг эрдэнэсийн сан, Дорно дахины анагаах ухааны чухал бүрэлдэхүүн болно. XVII зууны үеийн ар Монголын Зая бандида Лувсанпринлэй түүний зохиолдоо Ганжуур, Данжуурын доторх, Энэтхэгийн анагаах ухааны зохиолуудыг нэлээд дэлгэрэнгүй танилцуулахын хамт Төвдийн Анагаах ухааны дөрвөн үндэсийн буй болсон тухай бичсэн байдаг. Эрдэмтэн Ш.Болд (2011) Б.Халиунаа (2019) “Монголд мэс заслын ухаан хөгжсөн түүх” докторын бүтээлдээ Монгол маарамбуудын эдэлж хэрэглэглэж байсан мэс заслын багаж хэрэгсэл, арга ажиллагааны нэр томьёоны ижилсэл болон ялгааг түүхэн талаас нь анхлан системчилсэн бол Я.Ганбаяр (2008) Лүнригдандарын Дөрвөн үндсийн гарсан ёс хиргүй биндэрьяа толь хэмээх анагаах ухааны түүхийн зохиолд Энэтхэг, Төвдийн анагаах ухааны түүхийг нэлээд дэлгэрэнгүй бичиж, буддын шашин Монголд уламжлагдсан ба түүнийг дагалдан Төвдийн анагаах ухааны дөрвөн үндэс Монголд орж ирснийг тусгасан байсан. Хэдийгээр эдгээр эрдэмтэд онолын болон түүхэн ерөнхий хүрээг тогтоосон боловч яг ямар сурвалжийн аль бүлэгт Аюурведийн мэс заслын ойлголт Монгол ахуйд хэрхэн нутагшин өөрчлөгдсөн, анхны эх сурвалжаасаа хэрхэн хувьссан болохыг харуулсан сурвалж судлалын нарийвчилсан нотолгоо хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, Аюурведийн сонгодог эх бичвэрүүд (*Sushruta Samhita* г.м) болон Монгол эмч нарын туурвисан тайлбар зохиолуудын хоорондох текст хоорондын (intertextual) харьцуулалт, эмнэлзүйн зөвлөмжийн өөрчлөлтийг баримтжуулсан судалгаа дутмаг байна.

Тиймээс Монгол эрдэмтдийн бүтээсэн голлох сурвалжуудад туссан Аюурведын анагаах ухааны нөлөөллийг илрүүлэн тодорхойлох, эмчилгээний арга зүй болон өвчний ангилал зүйд Аюурведын уламжлал хэрхэн шингэсэн болохыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоох нь чухал ач холбогдолтой. Энэ нь зөвхөн түүхэн шинжилгээ хийхээс цааш,

МУАУ-ны суурийг бүрдүүлсэн олон эх сурвалжийн нөлөөлөл, мөн соёл хоорондын мэдлэгийн солилцоог илүү өргөн хүрээнд ойлгох боломжийг бүрдүүлнэ. Иймд дээр дурдсан үндэслэлүүдийг харгалзан Аюурведын нөлөөллийг цаг хугацааны хэлхээ, орчуулгын уламжлалтай уялдуулан судлах нь МУАУ-ны хөгжлийн түүхэн төлөвшилийг гүнзгий, олон төвт болон соёл хоорондын уялдаанд суурилсан хэлбэрээр танин ойлгоход чухал гэж үзэж, энэхүү судалгааны сэдвийг сонгосон.

Зорилго: Монголын уламжлалт анагаах ухааны тодорхой эх сурвалжуудад Аюурведийн анагаах ухааны ойлголт, тэр дундаа өвчний ангилал зүй болон мэс заслын уламжлал хэрхэн туссаныг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан, Монгол эмч нарын эмнэлзүйн хэрэглээндээ хэрхэн уламжлан авч, баяжуулсан зүй тогтлыг гаргахад оршино.

Зорилт:

1. Монголын уламжлалт анагаах ухааны сонгомол эх сурвалжуудад буй Аюурведийн анагаах ухаантай холбоотой мэдээллийг илрүүлэх зорилгоор сэдэвчилсэн кодчиллол болон агуулгын дүн шинжилгээний (content analysis) аргыг ашиглан нэр томьёо, ойлголтуудыг системчлэн ангилах.
2. Өвчний ангилал зүй” болон “мэс заслын арга ажиллагаа” гэсэн үндсэн кодчиллын хүрээнд илэрсэн өгөгдлүүдийг Аюурведийн сонгодог зохиолуудтай (*Sushruta Samhita, Ashtanga Hridayam* г.м) харьцуулан шинжилж, онолын болон практик залгамж холбоог тогтоох.

Арга, аргачлал: Бид судалгааны ажилдаа Аюурведийн анагаах ухааны Сушрутасамхита Англи хэл дээр 762 х (1907) Аштанга Хридая Самхита Англи хэл дээр 579 х Монголын үндэсний номын сан, Этүген их сургуулийн номын санд, Сүмбэ хамба Ишбалжирын Дөрвөн рашаан 686х (1994) хуучин монгол бичигээр Оточ манрамба дээд сургуулийн номын сан, Миндол Номун Хаан Жамбалчойжиданзанпэрэнлэй Увдисын далайг 520х (2014) Монгол хэлээр Этүгэн их сургуулийн номын санд хадгалагдаж байгаа материалыг ашиглав.

Уг судалгааг гүйцэтгэхдээ задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргууд болох:

1. Сэдвээр бүлэглэх судалгааны арга (Thematic analysis)
2. Агууламжийн судалгааны арга (Content analysis)
3. Эх сурвалж харьцуулан судлах аргуудыг ашиглана.

Уламжлалт анагаах ухааны сурвалж судлалын салбарт кодлон судлах аргуудыг ашиглах нь ирээдүйтэй чиг хандлага бөгөөд тухайн судалгааны хэрэглэгдэхүүнд агуулагдах асар их мэдээллийг үр дүнтэйгээр цомхтгох өргөн бололцоог олгодог. Бид энэхүү судалгаанд энэхүү кодлон судлах аргуудыг сурвалж бичиг судлалд зохицуулан (Н.Батсайхан, С.Сээсрэгдорж, Анагаах ухааны эх сурвалжийн судалгаанд кодлон ангилах аргачлалуудыг ашиглах асуудалд. Нэгтгэмэл Анагаах Ухаан сэтгүүл. 2021:8(2):72-78) хөгжүүлсний дагуу ашиглахаар төлөвлөлөө.

Үр дүн: Бидний судалгааны ажлын эхний зорилтын хүрээнд судалгааны хэрэглэгдэхүүнээр сонгогдсон дээр нэр дурдагдсан анагаах ухааны бүтээлүүдэд агууламжийн болон сэдвээр бүлэглэх судалгааг явууллаа.

Шүүмжийг хүлээн авч судалгааны ажилыг кодчилолыг орууллаа. Бид зорилт нэгийн хүрээнд өвчний ангилал зүйг авч үзэж, эмчилгээ, идээ, явдал мөр, өвчний нөхцөл, өвчний нэр, өвчний ангилал, өвчний шинж тэмдэг, өвчний оношлогоо, өвчний эдгэрсэн шинж, өвчний урьдчилан сэргийлэлт мэс засал хийх арга талаар код үүсгэсэн үүний үндсэнд нийт 28 мэс ажилбар хийдэг өвчний ангилал зүй гарч ирсэн. Үүнд Нүд, чих, толгой, хамар, амны өвчин, тулай, хошногны гөвдрүү, Давсагны чулуу, хэвлийн ивэрхий, ашиг, төрөлт саатсан үед ургийг умайд эвдэж гаргах, Ясны хавдрыг хусах, мэсийн шарх, хүзүүний шарх, гишүүний шарх, үе мултрал, булчирхайн өвчин, яс хугарч арьсыг нэвтлэн гарч ирсэн, толгой хагарсан, хавдар, хөхний буглаа, хэвлийн усжилт, шамбарам, арьсны өвчин, бэлгэсийн өвчин, зүү, зэв залгих, Шар усны өвчин яр идээ, буглаа, шулуун гэдэсний цоорол гэсэн өвчнүүдийг авж эх сурвалжуудтай харьцуулсан агууламжийн судалгааны үр дүнд илэрсэн аюурведийн анагаах ухааны холбогдол бүхий мэдээллүүдийг зохиол тус бүрээр гаргаж тоон утгад шилжүүлээ.

Үүний дараа судалгааны хэрэглэгдэхүүнд хийсэн агууламжийн судалгааны үр дүнд цугласан нийт кодыг нэгтгэн сэдвээр бүлэглэн аюурведийн анагаах ухаанаас монгол эрдэмтэд ямар сэдвийг голчлон суралцаж, эмчилгээ үйлчилгээний үйл ажиллагаандаа ашиглаж байсан болохыг тодрууллаа. Сүмбэ хамба Ишбалжирын Рашааны цагаан шүүхэр бүтээл дахь Аюурведийн анагаах ухааны өвчний ангилал зүйн мэдээлэл нийт 28 төрлийн эмгэгийн үед мэс заслын арга ашиглан эмчилдэг байсанаас хамгийн олон буюу 9 (42.8%) тохиолдол бодоо, тэмбүү, яр шарх зэрэг нь орчин үеийн анагаах ухааны ойлголтоор өвчин үүсгэгч эмгэг төрүүлэгчээр үүсгэгдэх эмгэгүүд болох тул халдвар гэсэн нийтлэг тодорхойлолтын доор 5 (23.8%) нь бэртэл гэмтэл, үлдсэн 7 (33.3%) тохиолдол нь нүдний өвчин, хавдар, бага сага загатнах, цагаан мах урвах, архинд донтох, халуун орны нүд шарлах өвчин, дурьдал буурч мартамхай болох гэсэн эмгэгүүд байна. Үүний зэрэгцээ дээрх 28 төрлийн эмгэгийн мэдээлэлд өвчин үүсэх нөхцөл, ангилал, шинж тэмдэг, оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, идээ, явдал мөр, эдгэрсэн шинж гэсэн найман төрлийн кодоор түүвэрлэн ялгахад давхардсан тоогоор нийт 34 тохиолдол илэрлээ. Үүнд:

Идээ, явдал мөр-2, урьдчилан сэргийлэлт -2, шинж тэмдэг-4, ангилал-1, өвчин үүсэх нөхцөл-1, оношлогоо-1, эдгэх шинж-1, эмчилгээ-22

Увдисын Далай бүтээлд дэх Аюурведийн анагаах ухааны мэдээ 28 төрлийн эмгэгийн үед уг анагаах ухааны арга туршлагаудыг хэрэглэхийг заажээ. Эдгээр 28 тохиолдлын хамгийн олон буюу 8 (47.05%) тохиолдол халдвар гэсэн нийтлэг тодорхойлолтын доор, 4 (24.0%) нь бэртэл гэмтэл, 5 (29.4%) нь бусад

өвчин буюу нүдний өвчин, шүдний өвчин, бахуу өвчин, доод биеийн хүйтэн, тамир барагдсан өвчин, хөрөнгө цувирах гэсэн тодорхойлолтод багтаж байна. Эдгээр 28 эмгэгийг өвчний шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт гэсэн дөрвөн төрлийн кодоод давхардсан тоогоор нийт 28 тохиолдол илэрсэнээс эмчилгээ 25, шинж тэмдэг 2, урьдчилан сэргийлэлт тус бүр 1 байна.

Сүмбэ хамба Ишбалжирын Мэсийн шарх Бэртэл гэмтлийн бүлэгт хамаарагдах эмчилгээнд Цалгар нэг лан, номхотгосон дарцур нэг лан, сувд, бойгар, цалгод тус бүр гурван цэн, зааны соёо, зааны арьс, бойшэл, шүр тус бүр таван цэн, данда гурван лан, утаа хөө таван лан, гантиг, дожа, шэлда, лууны яс нугуудыг найруулж түрхвэл хатаана. Үүнийг бас ялбараагүй шарханд талбиж болно гэсэн бол Тархи унасанд оношлогоо Утсаар хэмжиж үзэхэд урт богино болж байвал мөн болой. Эмчилгээ үүнийг чихнээс нь татаж байгаад усаар ташуурдах буюу хусаараар алгадна. Ингээд эс болвол хатавчны дээр шилээр нь дэрлүүлж хэвтүүлээд хоёр хөлийнх нь уланд тэгшхэн банз талбиж цохино. Мэс, модонд цохигдох эмчилгээ биед үлдэж хоцорсон гэдгийг шинжиж мэдсэний хойно хэрвээ зэв байвал ирвэсийн цөс түрхэх ба мод байвал зааны соёо түрхвэл тустай.

Хэлцэмж: Бидний судалгаагаар Сүмбэ хамба Ишбалжирын "Рашааны цагаан шүүхэр" болон "Увдисын далай" бүтээлүүдэд агуулгын шинжилгээ (Content analysis) хийхэд Аюурведийн анагаах ухааны (ABAY) арга зүйгээр эмчилдэг нийт 28 төрлийн мэс заслын өвчин тодорхойлогдсон юм. Энэхүү үр дүн нь Аюурведийн "Сушрута Самхита" болон "Аштанга Хридая" бүтээлүүдийн мэс заслын үзэл санаа Монголын анагаах ухааны практикт зөвхөн онолын төдий бус, эмчилгээний тодорхой тактик болон нутагшсан болохыг гэрчилж байна.

Судалгааны хүрээнд хийгдсэн сэдэвчилсэн кодчилолын үр дүнгээс үзэхэд "Рашааны цагаан шүүхэр" бүтээлд дурдагдсан 28 төрлийн эмгэгийн 42.8%-ийг халдварт шинжтэй эмгэгүүд (бодоо, тэмбүү, яр шарх), 23.8%-ийг бэртэл гэмтэл эзэлж байгаа нь Аюурведийн мэс заслын "Agantuja" буюу гадны нөлөөт өвчний ангилалтай шууд дүйцэж байгаа юм.¹

Бидний хийсэн агуулгын шинжилгээгээр "Эмчилгээ"-ний код хамгийн өндөр давтамжтай (22-25 тохиолдол) илэрсэн нь Монгол оточ нар Аюурведийн онолоос илүүтэйгээр практик мэс ажилбар, шархны эмчилгээний арга техникийг голчлон өвлөн авсныг баталж байгаа юм. Сүмбэ хамба Ишбалжир мэсийн шархыг анагаахдаа сувд, шүр, зааны соёо, лууны яс зэрэг 15 гаруй төрлийн эрдэс болон амьтны гаралтай бодисыг найруулж байгаа нь Сушрутагийн сургааль дахь шархны заслын "Sasti Upakrama" буюу 60 төрлийн заслын зарчимтай логик уялдаатай байна.⁵ Энэхүү нарийн найрлага нь МУАУ-ны шархны засалд халууныг дарах, идээг татах зорилгоор хэрэглэгддэг Аюурведийн бодисын чадлын онол (Dravya Guna)-ын практик хэрэгжилт юм.

Судалгааны үр дүнд илэрсэн "Тархи унах" үеийн оношлогоог утсаар хэмжих, мөн "мэс, модонд цохигдох" үед биед үлдсэн зэвийг ирвэсийн цөс, зааны соёогоор эмчлэх аргууд нь МУАУ-ны өвөрмөц онцлогийг тодотгож байна. Энэ нь Сушрутагийн бүтээлд дурдагдсан биед үлдсэн гадны биетийг (Shalya) гаргах найман төрлийн мэс ажилбарыг Монголын нөхцөлд тохируулан, эмийн бодисын хүчээр гадны биетийг "хөдөлгөх" буюу мэс ажилбарыг хөнгөвчлөх тактикийг ашиглаж байсны илрэл юм.¹⁰

Нийт 34 тохиолдолд хийсэн найман төрлийн кодын шинжилгээгээр "Идээ, явдал мөр" болон "Урьдчилан сэргийлэлт"-ийн давтамж харьцангуй бага байгаа нь Монголын мэс заслын уламжлалт сурвалжууд нь урьдчилан сэргийлэхээс илүүтэйгээр цочмог гэмтэл болон шархны яаралтай тусламжид чиглэж байсныг тодорхойлж байна. Энэ нь П.В.Шармагийн (1992) дурдсан Аюурведийн мэс заслын практик чиг хандлага МУАУ-д түлхүү хадгалагдан ирснийг гэрчилнэ.⁷

Дүгнэлт: Энэхүү судалгаа нь Монголын уламжлалт анагаах ухааны эх сурвалжуудад Аюурведийн өвчний ангилал зүй болон мэс заслын арга барил хэрхэн туссаныг илрүүлж, тэдгээр нь Монгол эмч нарын эмнэлзүйн практикт зөвхөн дамжигдаад зогсохгүй, өвөрмөц оношлогоо, эмчилгээний аргуудаар баяжин нутагшсан зүй тогтлыг нотлов. Ийнхүү Аюурведийн мэс заслын уламжлал нь Монголын анагаах ухааны эх сурвалж бичгүүдэд тусгагдахдаа соёл хоорондын мэдлэгийн солилцооны үр дүнд МУАУ-ын салшгүй хэсэг болон төлөвшсөнийг дүгнэлээ

Ном зүй

1. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх IV. 2-р хэвлэл. Улаанбаатар: Адмон принт; 2011.
2. Жигмэд Б. Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээ. Улаанбаатар: Soyombo Printing; 2009.
3. Dash, V. B. *Fundamentals of Ayurvedic Medicine*. 1998:8–30. 1998:8-30.
4. Болдсайхан Б. Буддын сургаал ба шинжлэх ухаан. Улаанбаатар: Адмон; 2003.
5. Цэнд-Аюуш Д, Алимаа Т, Цэрэнцоо Б, Батнайрамдал Ч,

- Баярмаа Б. Монголын уламжлалт анагаах ухааны онол. Улаанбаатар: Мөнхийн үсэг; 2017.
6. Болд Ш. Гүн ухаан, онол, эрүүл биеийн судлал. Улаанбаатар: Мөнхийн үсэг; 2012.
7. Дагвацэрэн Б. Цог заль төгөлдөр дөрвөн үндэсийн номлохуйн үндэс тайлбар, тайлал. Улаанбаатар: Жиком Пресс; 2015.
8. Filliozat, J. *The Classical Doctrine of Indian Medicine*. New Delhi; 1964:5.
9. Murthy, S. K. R. *Luminaries of Indian Medicine*. Varanasi, India; 1997:12–28.
10. Ганбаяр Я. Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс зохиолын судалгаа [Докторын зэрэг горилсон бүтээл]. Улаанбаатар: АШУУИС; 2008.
11. Ганболор Б. Төвөдийн уламжлалт анагаах ухааны түүхийн тойм судалгаа. Улаанбаатар; 2019:35.
12. Дагвацэрэн Б. Монгол-Төвөдийн уламжлалт анагаах ухааны онол арга зүйн үндсэн зүй тогтол. Улаанбаатар; 1995.
13. Баавгай Ч, Болдсайхан Б. Монголын уламжлалт анагаах ухаан. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар; 1990:7–47.
14. Тисрондэзан, Жамбапринлай. Төвөдийн анагаах ухааныг баригчдын үе залгамжлагчдын намтар. Улаанбаатар: АХХ; 2000.
15. Бурханы шашныг гийгүүлэгч номын гарах орон сайтар зарлигийн Эрдэнийн сан. (Хэвлэлийн мэдээлэл дутуу).
16. Даржаа Х. Ганжуур судар дахь өвчнийг тарниар анагаах аргын эх бичгийн судалгаа. Улаанбаатар; 2022:22.
17. Монгол ганжуур данжуурын гарчиг. Улаанбаатар: Алса; 1993.
18. Монгол анагаах ухааны судар бичгийн чуулган, боть 1: Монгол Ганжуур, Данжуур дахь тэжээхүйн ухааны эмхэтгэл. Бээжин: Үндэсний хэвлэлийн хүрээ; 2022:824.
19. Даваадагва Д. Монгол данжуурын доторх найман гишүүнтийн зүрхний хураангуй дахь зарим тангийн судалгаа. Улаанбаатар; 2011:35-36, 75.
20. Мэндийн Б. Найман гишүүнтийн зүрхнийг хураасан дахь гурван гэмийн онолыг зарим эх сурвалжтай харьцуулах судалгаа. Улаанбаатар; 2020:48.
21. Жамбалпринлай. Төвөдийн анагаах ухааныг баригчдын үе залгамжлагчдын намтар. 2000.
22. Болд Ш. Халуун, хүйтэн судасны илрэлийн талаархи Монголын уламжлалт анагаах ухааны онолын мөн чанарыг судлах асуудал. 1998:21.
23. Байгалмаа Ү. Монголын уламжлалт анагаах ухааны оношлогоо. Улаанбаатар; 2006:14-30.
24. Буянт Б. Хүннүгийн анагаах ухааны түүхийн судалгаа [Докторын зэрэг горилсон бүтээл]. Улаанбаатар; 2006.
25. Халиунаа Б. Монголд мэс заслын ухаан хөгжсөн түүх [Докторын зэрэг горилсон бүтээл]. Улаанбаатар; 2019.

"A Comparative Study on the Principles of Categorizing Surgical Diseases: Ayurveda vs. Traditional Mongolian Medicine

Davaadulam E¹, Batsaikhan N¹, Batnairamdal Ch²

¹ School of Mongolian Traditional Medicine, MNUMS

² Central Hospital of Traditional Mongolian Medicine, MNUMS

E-mail: Btd24f053@gt.mnnums.edu.mn, Tel: +976-95965333

Abstract:

Background: Traditional Mongolian Medicine (TMM) is a unique repository of knowledge developed through the integration of Indian Ayurveda, Tibetan medical theories, and various therapeutic methods from Chinese medicine. Scholars emphasize that the "Ashtanga Hridayam Samhita," a foundational Ayurvedic text, played a pivotal role in the formation of the "Four Medical Tantras" (FMT), which serves as the ideological basis for both Tibetan and Mongolian medicine. Although historians such as B. Jigmed, Sh. Bold, and Ya. Ganbayar have explored the general historical development of TMM, there remains a significant gap in intertextual comparative research regarding how Ayurvedic surgical concepts were localized and adapted within the Mongolian context. Thus, identifying the Ayurvedic surgical traditions reflected in the works of prominent Mongolian scholars, such as Sumbe Khamba Ishbaljir and Mindol Nomun Khan Jambalchoijidanzanperinlei, is essential for a deeper understanding of the historical evolution of TMM.

Aim: The purpose of this study is to analyze the reflection of Ayurvedic concepts—specifically disease taxonomy and surgical traditions—within selected sources of TMM and to determine the patterns of how Mongolian physicians adopted and enriched these practices in their clinical applications.

Materials and Method: The study utilized the *Sushruta Samhita* (English ed., 1907) and *Ashtanga Hridayam Samhita* as primary Ayurvedic references, alongside Mongolian historical sources, including Sumbe Khamba Ishbaljir's *Four Medical Tantras* (1994 edition) and Mindol Nomun Khan's *Ocean of Instructions* (2014 edition). Research methods included thematic analysis, content analysis, and comparative source studies. Furthermore, systematic coding methods adapted for historical source research were employed to efficiently condense the extensive information within the materials.

Results: Content and thematic analysis of the selected sources identified 28 distinct types of surgical diseases categorized based on Ayurvedic methodology. These include physical trauma, systemic disorders, and various infectious and dermatological conditions. In Sumbe Khamba Ishbaljir's *White Parasol of Healing*, infectious diseases accounted for 42.8% and physical injuries for 23.8% of these surgical cases, while in the *Ocean of Instructions*, infectious diseases represented 47.05% and injuries 24.0%. Across both sources, the "Treatment" code appeared with the highest frequency (n=22–25), demonstrating that Mongolian scholars prioritized the inheritance of practical surgical instructions over theoretical abstraction. In terms of practical application, the use of complex ointments consisting of over 15 ingredients, such as pearls, coral, and ivory, for treating weapon wounds aligns with Ayurvedic pharmacological theories. Additionally, unique methods such as diagnosing "Brain Displacement" through string measurement and extracting embedded foreign objects (metal or wood) using leopard gall and ivory confirm that Ayurvedic surgical tactics were localized and enriched within the Mongolian medical tradition.

Conclusion: The study concludes that the principles of Ayurvedic surgical and disease taxonomy were not merely copied into Mongolian sources but were systematically adapted to the Mongolian climate and lifestyle. Mongolian scholars, including Sumbe Khamba Ishbaljir, enriched the Ayurvedic *Shalya Tantra* (Surgical Science) with practical techniques and unique medicinal compositions for managing infectious wounds and trauma, thereby defining the independent developmental trajectory of surgery within Traditional Mongolian Medicine.

Keywords: Sushruta Samhita, Thematic coding, Tengyur, Content analysis, Comparative study